

**ГАЗАРЗҮЙ**

**2008**

ХУВИЛБАР А


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Европ тив Ази тив хоёрыг заагладаг шугамыг зөв сонго. (1 оноо)
  - А. Скандиновын хойг, Зүүн европ, Хар тэнгис, Босфорын хоолой
  - В. Уралын нуруу, Арал тэнгис, Кавказын нуруу, Хар тэнгис, Босфорын хоолой
  - С. Уралын нуруу, Каспийн тэнгис, Кавказын нуруу, Персийн булан
  - Д. Уралын нуруу, Ижил мөрөн, Хар тэнгис, Карпатын нуруу
  - Е. Уралын нуруу, Каспийн тэнгис, Кавказын нуруу, Хар тэнгис, Босфорын хоолой
2. Өвлийн улиралд эх газраас далай руу, зуны улиралд далайгаас эх газар руу чиглэлээ өөрчилдөг салхийг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
 

А. Фён	В. Пассат	С. Муссон
Д. Бриз	Е. Баруун зүгийн салхи	
3. Чулуулгийг гарал үүслээр нь Тунамал, Хувирмал, Магмын гэж 3 ангилдаг. Дараах чулуулгийн төрлүүдээс тунамал гаралтай чулуулгийг сонго. (1 оноо)
 

А. Гантиг	В. Элс	С. Боржин	D. Кварц	E. Хээрийн жонш
-----------	--------	-----------	----------	-----------------
4. Дараах зурагт Атакамын цөлийг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5



5. Дэлхийн үнэмлэхүй бага температур болох  $-89.2^{\circ}\text{C}$  тэмдэглэгдсэн газар аль эх газарт харъяалагдах вэ? (1 оноо)
 

А. Еврази	В. Австрали	С. Антарктид
Д. Хойд америк	Е. Өмнөд америк	
6. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан орныг сонго. (1 оноо)
 

А. Гүрж	В. Румын	С. Болгар
Д. Югослав	Е. Шри-Ланк	
7. Хойд америкийн хамгийн нам цэг аль нь вэ? (1 оноо)
 

А. Турфан	В. Сөнөсөн тэнгис	С. Вальдес хойг
Д. Үхлийн хөндий	Е. Эйр нуур	
8. Тогтмол салхиар туугдаж үүсдэг далайн урсгалыг ..... урсгал гэнэ. (1 оноо)
 

А. Нягтын	В. Дрейф	С. Нөхөх
Д. Хүйтэн	Е. Дулаан	
9. Дараах улсуудаас аль нь баруун өмнөд азийн бүс нутагт хамрагдах вэ? (1 оноо)
 

А. Туркменистан	В. Тайланд	С. Энэтхэг
Д. Иран	Е. БНСУ	
10. Дэлхийн байгалийн каучукийн 60-аас дээш хувийг бүрдүүлдэг улсуудыг сонго. (1 оноо)
 


А. Малайз, Индонез	В. Тайланд, Шри-ланк	С. Бразил, Колумб
Д. Энэтхэг, Хятад	Е. Ангол, Гвиней	
11. Дараах улсуудаас АСЕАН-ий бүрэлдэхүүнд ордог улсыг сонго. (1 оноо)
 

А. Камбож	В. Пакистан	С. Узбекистан
Д. Саудын арав	Е. Монгол	

12. Байгаль экологийн тулгамдсан асуудалд аль ойлголт нь хамаарагдахгүй вэ? (1 оноо)  
 А. Хүлэмжийн хий В. Озоны давхарга нимгэрэх С. Хөрсний бохирдол  
 D. Агаарын бохирдол E. Хүн амын ердийн өсөлт
13. Дараах боомт хотуудаас аль нь Атлантын далай дахь боомт хот вэ? (1 оноо)  
 А. СанФранциско В. Лиссабон С. Токио  
 D. Бомбей E. Сидней
14. Палеозойн эринд хамаарагдах галавыг сонго. (1 оноо)  
 А. Цэрд В. Пермь С. Дөрөвдөгч  
 D. Палеоген E. Неоген
15. НҮБ-ын Шинжлэх Ухаан, Боловсрол, Соёлын байгууллагын “Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд манай улсаас аль дархан газар бүртгэгдсэн вэ? (1 оноо)  
 А. Дорнод тал В. Ханхэнтий С. Говийн их  
 D. Нөмрөг E. Говийн бага
16. Ачаа эргэлт гэж юу вэ? (1 оноо)  
 А. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замаар нь үржүүлсэн үзүүлэлт  
 В. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ  
 С. Зорчсон хүний тоог явсан замын уртаар үржүүлсэн үзүүлэлт  
 D. Нийт зорчсон хүний тоо  
 E. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замд хуваасан үзүүлэлт
17. Евразийн гадаргын дундаж өндөр аль нь вэ? (1 оноо)  
 А. 830 В. 750 С. 720  
 D. 580 E. 2040
18. Ажил эрж байгаа мэргэжилтэй хүн түүнд шаардлагатай ажлын байр хоёр бараг тэнцүү бөгөөд бие биесийг олох зуурт гардаг ажилгүйдлийн хэлбэрийг ..... гэнэ. (1 оноо)  
 А. Ажилгүйдлийн жирийн түвшин В. Илүүдэл ажилгүйдэл  
 С. Мөчлөгийн ажилгүйдэл D. Хүмүүн капитал  
 E. Ажиллах хүч
19. 12-р сарын 22-нд эдгээр хотуудын алинд нь өдөр хамгийн богино үргэлжлэх вэ? (1 оноо)  
 А. Сайншанд В. Замын-Үүд С. Улаанбаатар  
 D. Сүхбаатар E. Дархан
20. Эрэлт гэж юу вэ? (1 оноо)  
 А. Хүний хэрэгцээг хангаж буй бүхий л хэрэгсэл нөөц  
 В. Хүний хангагдаагүй хүсэл буюу дутагдалтай байгаа зүйлс  
 С. Үйлдвэрлэсэн, худалдахад бэлэн байгаа барааны тоо хэмжээ  
 D. Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээ буюу төлбөрийн чадвартай хэрэгцээ  
 E. Нэгж нөөцөөр бүтээсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ
21. Манай он тооллын 1-р зууны үед Палестинд анх үүссэн шашин аль нь вэ? (1 оноо)  
 А. Лал В. Будда С. Христос  
 D. Хинди E. Синто
22. Монгол орны говь цөлийн бүсэд ургадаг ургамлуудыг сонго. (2 оноо)  
 А. Харгана, Боролзой, Заг, Бударгана, Тоорой  
 В. Жамъянмядаг, Хонгорзул, Сибир хундгана, Хус, Улиас  
 С. Ерхөг, Агь, Таана, Хялгана, Жодоо  
 D. Гоёо, Боролзой, Заг, Бударгана, Хуш  
 E. Шивээ, Хиаг, Ботуул, Монгол тост, Шинэс
23. Доорх өгөгдлүүдийг уншаад зөв бурууг ялган тэмдэглэснийг олж дугуйл. (2 оноо)  
 1. Монгол орон Ази тивийн төв хэсэгт уртрагийн дагуу сунаж тогтсон  
 2. Манай орны хамгийн баруун захын цэг нь Баян-Өлгий аймгийн нутагт оршдог  
 3. Манай улс Казакстан, Румын, Франц улстай нэг өргөрөгт оршино  
 А. 1 Тийм 2 Үгүй 3 Тийм  
 В. 1 Тийм 2 Үгүй 3 Үгүй  
 С. 1 Үгүй 2 Үгүй 3 Тийм  
 D. 1 Үгүй 2 Тийм 3 Тийм  
 E. 1 Үгүй 2 Үгүй 3 Үгүй
24. Манай орны хойд захын цэгээс өмнөд захын цэг хүртэл өргөргийн хэдэн градусын зөрөө байдаг вэ? (2 оноо)  
 А.  $11^{\circ}34'$  В.  $10^{\circ}34'$  С.  $11^{\circ}44'$   
 D.  $10^{\circ}25'$  E.  $11^{\circ}04'$

25. Байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийг схемд гүйцээж бөглөх зөв хариултыг сонго. (2 оноо)

- A. Гол мөрөн, рашаан
- B. Нуур, тэнгис
- C. Хөрс, Ургамал
- D. Хөрс, агаар
- E. Ашигт малтмал, хүдэр



26. Аялагч Улаанбаатар хотоос манай орны хамгийн гүн нуур болох Хөвсгөл нуур хүрэх хамгийн дөт замыг сонгожээ. Аялагч аль замыг сонгосныг олж дугуйл. (2 оноо)

- A. Улаанбаатар - Дархан - Эрдэнэт - Хөвсгөл нуур
- B. Улаанбаатар - Цэцэрлэг - Мөрөн - Хөвсгөл нуур
- C. Улаанбаатар - Булган - Мөрөн - Хөвсгөл нуур
- D. Улаанбаатар - Арвайхээр- Цэцэрлэг - Мөрөн - Хөвсгөл нуур
- E. Улаанбаатар - Дархан - Сүхбаатар - Мөрөн - Хөвсгөл нуур

27. Дараах өгөгдлөөс хөгжиж буй орнуудын аж ахуйн онцлогийг илэрхийлэх нийтлэг нэг шинжийг сонго. (2 оноо)

- A. Аж үйлдвэр нь ХАА-гаас 5-10 дахин их бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг
- B. Олон салбарын аж ахуйтай, гадаад худалдаа ихээр хөгжсөн
- C. ХАА нь эрчимжсэн, их хэмжээний таваарын бүтээгдэхүүн гаргадаг
- D. Боловсруулах үйлдвэр нь ХАА, уул уурхайн бүтээгдэхүүний анхны боловсруулалт хийж, экспортод гаргахад зориулагдсан
- E. Түүхий эд ихээр импортолж, бэлэн бүтээгдэхүүн ихээр экспортлодог

28. Дараах Африкийн улсуудаас далайд гарцгүй орныг сонго. (2 оноо)

- A. Чад
- B. Алжир
- C. Сомали
- D. ӨАБНУ
- E. Марокко

29. Дараах аймгуудаас аль нь ОХУ-тай хиллэдэггүй вэ? (2 оноо)

- A. Дорнод
- B. Баян-Өлгий
- C. Дархан-Уул
- D. Хэнтий
- E. Завхан

30. Доор өгөгдсөн бүс нутгуудыг газрын тосны судлагдсан нөөцийн хэмжээгээр нь зөв дарааллуулсан хувилбарыг сонгоно уу. (2 оноо)

- |                       |                      |                  |
|-----------------------|----------------------|------------------|
| A. 1 Баруун өмнөд ази | 2 ОХУ, Баруун сибирь | 3 Зүүн өмнөд ази |
| B. 1 Баруун өмнөд ази | 2 ОХУ, Баруун сибирь | 3 Хойд африк     |
| C. 1 Баруун европ     | 2 ОХУ, Баруун сибирь | 3 Хойд африк     |
| D. 1 Баруун өмнөд ази | 2 Өмнөд европ        | 3 Латин америк   |
| E. 1 Хойд америк      | 2 Өмнөд африк        | 3 Латин америк   |

31. Доорх зурагт Ханхын боомтыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (2 оноо)

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5




32. Дараах улс орнуудыг нийслэлтэй нь зөв тохируулсан хувилбарыг сонго. (2 оноо)

Дугаар	Улс орны нэр	Индекс	Нийслэл
1	Энэтхэг	а	Вьентьян
2	Сири	б	Душанбе
3	Лаос	в	Дели
4	Тажикстан	г	Дамаск

А. 1б 2в 3г 4а                      В. 1б 2г 3а 4в                      С. 1г 2в 3а 4б  
 Д. 1в 2а 3г 4б                      Е. 1в 2г 3а 4б

33. Зурагт экваторын шугамаас А хот хүртэл уртрагийн дагуу 3888.5 км зайтай бол А хот ямар өргөрөгт оршиж байгааг ол. (2 оноо)


- А. ХӨ 30°  
 В. ХӨ 38°  
 С. ХӨ 35°  
 Д. ХӨ 45°  
 Е. ХӨ 40°



34. Тэжээлийн байдал, урсацын горимд үндэслэн гол мөрдийг хэв шинжүүдэд хуваадаг. Жилд унах тунадас их, усны баланс нь эерэг учир усны хэмжээ нь жилийн турш жигд байдаг голууд аль хэв шинжид хамрагдах вэ? (2 оноо)

- А. Экваторын                      В. Тропикийн                      С. Субэкваторын  
 Д. Туйлын                      Е. Нуурын

35. Нар сар дэлхий гурвын харилцан байрлал үргэлж өөрчлөгдөж байдаг. Ямар байрлалд нар хиртэх боломжтой вэ? (2 оноо)




36. Мэлхийн зам ямар ямар эх газруудын хэсгийг дайран өнгөрөх вэ? (2 оноо)  
 А. Хойд америк, Өмнөд америк, Антарктид                      В. Хойд америк, Хойд африк, Өмнөд ази  
 С. Өмнөд америк, Өмнөд африк, Австрали                      Д. Хойд америк, Европ, Зүүн хойд ази  
 Е. Европ, Австрали, Хойд америк

37. Аймгуудыг ямар үзүүлэлтээр нь жагсааж бичсэнийг олж тэмдэглэ. (2 оноо)  
 1. Өмнөговь                      2. Говь-Алтай                      3. Дорнод                      4. Баянхонгор                      5. Дорноговь  
 А. Хүн амын тоогоор                      В. Тариалсан талбайн хэмжээгээр нь  
 С. Адуун сүргийн тоо толгойгоор нь                      Д. Газар нутгийн талбайн хэмжээгээр нь  
 Е. Ямаан сүргийн тоо толгойгоор нь

38. Зураг дээрх 1 гэсэн тоогоор тэмдэглэсэн өргөрөг дээр нар хэдийд эгц тусах вэ? (3 оноо)

- А. 12 сарын 22  
 В. 6 сарын 22  
 С. 3 сарын 22  
 Д. 9 сарын 22  
 Е. 1 сарын 4



**Боловсролын Үнэлгээний Төв**

39. Томоохон манхат элснүүдийг орших аймагтай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонго. (3 оноо)

Дугаар	Манхат элсний нэр	Индекс	Орших аймаг
1	Молцог	а	Өмнөговь
2	Бөөрөг	б	Сүхбаатар
3	Хонгор	в	Завхан
4	Бор хар	г	Увс

A. 1б 2в 3г 4а                      В. 1б 2г 3а 4в                      С. 1г 2в 3а 4б  
D. 1г 2а 3б 4в                      Е. 1в 2г 3а 4б

40. Дараах бүс нутгуудийг хүн амын нөхөн үйлдвэрлэлийн хэв шинжтэй нь зөв тохируулсан хариултыг сонго. (3 оноо)

1. Европ	а. Хүн амын өсөлт нь бага
2. Хойд америк	б. Хүн амын өсөлт нь их
3. Австрали	в. Хүн амын өсөлт нь тэг буюу хасах тэмдэгтэй
4. Африк	г. Хүн амын өсөлт нь дунд зэрэг

A. 1б 2в 3г 4а                      В. 1б 2г 3а 4в                      С. 1г 2в 3а 4б  
D. 1в 2а 3г 4б                      Е. 1в 2г 3а 4б

41. Дэлхийн томоохон гол мөрдийг орших эх газартай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонго. (3 оноо)

Дугаар	Гол мөрдийн нэр	Индекс	Орших эх газар
1	Замбези	а	Хойд америк
2	Парана	б	Африк
3	Меконг	в	Өмнөд америк
4	Миссисипи	г	Еврази

A. 1б 2в 3г 4а                      В. 1б 2г 3а 4в                      С. 1г 2в 3а 4б  
D. 1г 2а 3б 4в                      Е. 1в 2г 3а 4б

42. Завхан аймагтай хил залгах аймгуудыг зөв сонго. (3 оноо)

- A. Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий  
B. Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс  
C. Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Хэнтий  
D. Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий  
E. Хөвсгөл, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Өвөрхангай


43. Дараах үйлдвэр уурхайг олборлож буй ашигт малтмалтай нь зөв тохируулсан хувилбарыг сонго. (3 оноо)

Дугаар	Үйлдвэр уурхайн нэр	Индекс	Олборлох ашигт малтмал
1	Бор-Өндөр	а	Нүүрс
2	Адуунчулуун	б	Алт
3	Толгойт	в	Мөнгө
4	Асгат	г	Хайлуур жонш

A. 1б 2в 3г 4а                      В. 1б 2г 3а 4в                      С. 1г 2в 3а 4б  
D. 1г 2а 3б 4в                      Е. 1в 2г 3а 4б

44. Доорх зурагт 1, 2, 3 гэсэн тоогоор тэмдэглэсэн хуудасны нэрлэлийг зөв дугуйл. (3 оноо)

- A. 1 М - 48    2 L - 49    3 М - 47  
B. 1 М - 50    2 L - 49    3 М - 47  
C. 1 М - 48    2 L - 47    3 L - 46  
D. 1 М - 48    2 L - 49    3 М - 49  
E. 1 М - 50    2 L - 49    3 М - 48



45. Нэг уртраг дээр орших хоёр хотын хоорондох зай газрын зурагт 31 см зайтай бөгөөд хоёр хотын хоорондох өргөргийн зөрүү  $14^\circ$  бол уг зургийн масштаб хэд байсан бэ? (3 оноо)

- (Өргөргийн  $1^\circ$  -ын өнцөгт тулсан голдожийн нумын урт 111.1 км)  
A. 1 : 500000                      В. 1 : 15000000                      С. 1 : 50000000  
D. 1 : 1500000                      Е. 1 : 5000000


46. Доорх өгөгдлийг ашиглан Даланзадгад хотын чийглэгийн итгэлцүүрийг бодож ол. (3 оноо)  
 Унах тунадасны хэмжээ 132 мм  
 Уурших чадварын хэмжээ 1320 мм  
 А. 0.3      В. 0.1      С. 1452      D. 1188      E. 100

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

#### Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу.
- Жишээлбэл: Бодлогын хариу 1235 гарсан гэж үзвэл a -1, b-2, c-3, d-5 гэж бөглөнө.
- Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө.
- Жишээ нь: Бодлогын хариу 21.34 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариултын загварыг [ab,cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө a-2, b-1, c-3, d-4 гэж бөглөнө.

- 2.1. Туул гол тодорхой хэсэгтээ 60 м өргөн, 2 м гүн, урсгалын хурд нь 2 м/с бол усны зарцуулгыг ол. (4 оноо)
- 2.2. Далайн мандалд орших усан онгоцноос далайн ёроол руу дууны долгион илгээхэд илгээсэн долгион 5 секундын дараа эргэж ирсэн бол далайн мандлаас ёроол хүртэлх зайг ол. (Усанд дууны долгион тархах хурд 1500 м/с ) (4 оноо)
- 2.3. Анхны голдоч дээр 10:00 цаг болж байхад аль уртраг дээр 18:00 цаг болж байх вэ? (4 оноо)



- 2.4. Буд гаригийн нарнаас алслагдах зай одон орны нэгжээр 0.39 бол энэ гаригийн нарыг тойрох орбитийн хугацаа нь дэлхийн жилээр [a,bc] байна. (Кеплерийн III хууль үндэслэн бодно) (4 оноо)


### ХУВИЛБАР В

#### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Монгол улсыг гишүүнчлэлдээ бүртгэсэн Олон улсын байгууллагыг сонгоно уу. (1 оноо)  
 А. Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд  
 В. Зүүн өмнөд азийн орнуудын эвсэл  
 С. Газрын тос экспортлогч орнуудын эвсэл  
 D. Үндэстнүүдийн хамтын нөхөрлөл  
 E. Дэлхийн худалдааны байгууллага
2. Томоохон нуур, гол, тэнгисийн эрэг дээр ажиглагддаг өдөр шөнөөр чиглэлээ өөрчилдөг салхийг юу гэж нэрлэх вэ?  
 А. Фён      В. Пассат      С. Муссон  
 D. Бриз      E. Баруун зүгийн салхи
3. Чулуулгийг гарал үүслээр нь Тунамал, Хувирмал, Магмын гэж 3 ангилдаг. Дараах чулуулгийн төрлүүдээс Магмын гаралтай чулуулгийг сонго. (1 оноо)  
 А. Гантиг      В. Элс      С. Боржин  
 D. Хүлэр      E. Гнейс

4. Дараах зурагт Бенгалийн буланг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5



5. Дэлхийн хамгийн их тунадас унадаг газар алинд нь харъяалагдах вэ? (1 оноо)

A. Гималайн өвөр бэл	B. Австралийн зүүн хэсэг	C. Төв Ази
D. Хойд Европ	E. Андын нурууны баруун эрэг	

6. Жилд ирэх жуулчдын тоогоор Европ тивдээ тэргүүлдэг улсуудыг сонго. (1 оноо)

A. Франц, Испани	B. Герман, Швейцари	C. Итали, Австри
D. Грек, ИхБритани	E. Нидерланд, Дани	

7. Африк тивийн хамгийн нам цэг аль нь вэ? (1 оноо)

A. Ассаль нуур	B. Сөнөсөн тэнгис	C. Вальдес хойг
D. Үхлийн хөндий	E. Эйр нуур	

8. Далайн аль нэг хэсэгт усны түвшний гадаргад үүссэн тэгш бус байдлыг жигдрүүлэх замаар үүссэн урсгалыг ..... урсгал гэнэ. (1 оноо)

A. Нягтын	B. Дрейф	C. Нөхөх
D. Хүйтэн	E. Дулаан	

9. Дараах улсуудаас аль нь Зүүн өмнөд азийн бүс нутагт хамрагдах вэ? (1 оноо)

A. Казакстан	B. Тайланд	C. Энэтхэг
D. Иран	E. Монгол	

10. Дэлхийн хөвөн мяндас бэлтгэлийн талаас илүү хувийг бэлтгэдэг улс орнуудыг сонго. (1 оноо)

A. АНУ, Хятад	B. Перу, Бразил	C. Энэтхэг, Пакистан
D. Египет, Судан	E. Узбекистан, Киргизстан	

11. НАТО-гийн гишүүн орныг сонго. (1 оноо)

A. Австрали	B. Пакистан	C. Бразил
D. Малайз	E. Болгар	

12. Хотын тэсрэлт гэдэг нь ..... болно. (1 оноо)

- A. Хүн амын өсөлт нь тухайн хотын нутгийн бодит боломжоос олон дахин давж буй үзэгдэл
- B. Хотын эдийн засгийн түргэн хурдацтай хөгжил
- C. Хотын нийгэм соёлын үйлчилгээний өсөлт хөгжил
- D. Хотын хүн амын орлогын түвшний өсөлт
- E. Хотын хүн амд ядуучуудын эзлэх хувийн жин нэмэгдэх үйл явц

13. НАФТА-д АНУ, Мексик, Канад зэрэг улсууд багтана. Энэ байгууллагын үндсэн зорилго нь ..... болно. (1 оноо)

- A. Хөрөнгө оруулалт худалдааг дэмжих
- B. Цэрэг улс төрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх
- C. Шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагаа
- D. Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах
- E. Соёл урлаг боловсролын салбарт хамтран ажиллах

14. Кайнозойн эринд хамаарагдах галавыг сонго. (1 оноо)

A. Цэрд	B. Пермь	C. Девон	D. Силур	E. Неоген
---------	----------	----------	----------	-----------

15. Хойд америкийн гадаргын дундаж өндөр аль нь вэ? (1 оноо)

A. 830	B. 750	C. 720	D. 580	E. 2040
--------	--------	--------	--------	---------

16. НҮБ-ын Шинжлэх Ухаан, Боловсрол, Соёлын байгууллагын “Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд манай улсаас аль дархан газар бүртгэгдсэн вэ? (1 оноо)

A. Дорнод тал	B. Ханхэнтий	C. Богдхан уул
D. Нөмрөг	E. Говийн бага	




17. Хэрэгцээ гэж юу вэ? (1 оноо)  
 А. Хүний хэрэгцээг хангаж буй бүхий л хэрэгсэл нөөц  
 В. Хүний хангагдаагүй хүсэл буюу дутагдалтай байгаа зүйлс  
 С. Үйлдвэрлэсэн, худалдахад бэлэн байгаа барааны тоо хэмжээ  
 D. Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээ буюу төлбөрийн чадвартай хэрэгцээ  
 E. Нэгж нөөцөөр бүтээсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ
18. Ачаа тээвэр гэж юу вэ? (1 оноо)  
 А. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замаар нь үржүүлсэн үзүүлэлт  
 В. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ  
 С. Зорчсон хүний тоог явсан замын уртаар үржүүлсэн үзүүлэлт  
 D. Нийт зорчсон хүний тоо  
 E. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замд хуваасан үзүүлэлт
19. Манай оронтой нэг өргөрөгт орших улс аль нь вэ? (1 оноо)  
 А. Энэтхэг  
 В. Иран  
 С. Франц  
 D. Норвеги  
 E. Австрали
20. 3 сарын 22-нд дэлхийн аль нэг хэсэгт өдөр шөнийн үргэлжлэх хугацаа ямар байх вэ? (1 оноо)  
 А. Өдөр нь урт шөнө нь богино  
 В. Шөнө нь урт өдөр нь богино  
 С. Өдөр шөнийн үргэлжлэх хугацаа тэнцүү  
 D. Хамгийн урт өдөр хамгийн богино шөнө  
 E. Хамгийн богино өдөр хамгийн урт шөнө
21. Энэтхэгийн далайн боомт хот аль нь вэ? (1 оноо)  
 А. Дакар  
 В. Сан Паулу  
 С. Иокогама  
 D. Бомбей  
 E. Владивосток
22. Дараах улсуудын дотроос цэвэр зэсийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч орнуудыг сонгоно уу. (2 оноо)  
 А. Япон, Чили  
 В. Канад, ОХУ  
 С. Польш, Замби  
 D. Бельги, Голланд  
 E. Перу, Бразил
23. Экваторын шугам ямар ямар эх газруудын хэсгийг дайран өнгөрөх вэ? (2 оноо)  
 А. Өмнөд америк, Төв африк, Энэтхэгийн хойг, Суматра арал  
 В. Хойд америк, Хойд африк, Өмнөд ази  
 С. Өмнөд америк, Өмнөд африк, Австрали  
 D. Өмнөд америк, Төв африк, Суматра арал, Калимантан арал  
 E. Европ, Австрали, Хойд америк
24. Доорх зурагт Бичигтийн боомтыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (2 оноо)

- A. 1  
 B. 2  
 C. 3  
 D. 4  
 E. 5



25. Зураг дээрх 3 гэсэн тоогоор тэмдэглэсэн өргөрөг дээр нар хэдийд эгц тусах вэ?

- A. 12 сарын 22  
 B. 6 сарын 22  
 C. 7 сарын 4  
 D. 9 сарын 23  
 E. 1 сарын 4




**Боловсролын Үнэлгээний Төв**

26. Дараах аймгуудаас аль нь ОХУ-тай хиллэдэг вэ? (2 оноо)  
 А. Дорнод В. Өмнөговь С. Дархан-Уул  
 D. Дундговь E. Архангай

27. Хонин сүргийн тоо толгойгоор эхний гуравт ордог аймгуудийг зөв сонго. (2 оноо)  
 А. Завхан, Өвөрхангай, Баян-Өлгий В. Завхан, Архангай, Дорноговь  
 С. Архангай, Төв, Өмнөговь D. Завхан, Өвөрхангай, Хөвсгөл  
 E. Архангай, Төв, Хэнтий


28. Байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийг схемд гүйцээж бөглөх зөв хувилбарыг сонго. (2 оноо)  
 А. Гол мөрөн, рашаан  
 В. Нуур, тэнгис  
 С. Амьтан, ургамал  
 D. Хөрс, агаар  
 E. Ашигт малтмал, хүдэр



29. Доорх өгөгдлүүдийг уншаад, зөв бурууг ялган тэмдэглэснийг олж дугуйл. (2 оноо)  
 1. Монгол орон хойд талаараа ОХУ, өмнөд талаараа БНХАУ-тай тус тус хил залган оршино  
 2. Монгол улс нь Парламентын засаглалтай бүгд найрамдах улс юм  
 3. Монгол орны газрын гадарга хойноосоо урагшлах тутам өндөрсдөг  
 А. 1 Тийм 2 Үгүй 3 Тийм  
 В. 1 Тийм 2 Үгүй 3 Үгүй  
 С. 1 Үгүй 2 Үгүй 3 Тийм  
 D. 1 Тийм 2 Тийм 3 Үгүй  
 E. 1 Үгүй 2 Үгүй 3 Үгүй

30. Монгол орны Ойт хээрийн бүсэд зонхилон ургадаг ургамлыг сонго. (2 оноо)  
 А. Харгана, Боролзой, Заг, Бударгана, Тоорой  
 В. Жамъянмядаг, Хонгорзул, Сибир хундгана, Хус, Улиас  
 С. Ерхөг, Агь, Таана, Бударгана, Шинэс  
 D. Хонгорзул, Жамъянмядаг, Бударгана, Хус, Тооройы  
 E. Шивээ, Хиаг, Ерхөг, Монгол тост, Таана

31. Нар сар дэлхий гурвын харилцан байрлал үргэлж өөрчлөгдөж байдаг. Ямар байрлалд тэргэл сар харагдах вэ? (2 оноо)




32. АНУ-ын баруун хэсгийн уулархаг мужуудад хөгжсөн ХАА-н салбарыг сонгоно уу. (2 оноо)  
 А. Мал аж ахуй В. Техникийн ургамал тариалалт  
 С. Үр тарианы аж ахуй D. Төмс хүнсний ногоо  
 E. Шувууны аж ахуй

33. Хөдөлмөрийн газарзүйн хуваарь гэдэг нь ..... болно. (2 оноо)  
 А. Түүхийн явцад хүмүүсийн хөдөлмөрийн үйл ажиллагааны төрлүүд салан тусгаарлагдах процесс  
 В. Тодорхой нутаг дэвсгэр, үйлдвэрлэл аж ахуйн салбараар төрөлжин хөгжиж хоорондоо харилцан гадаад худалдаа хөгжүүлэх үйл явц  
 С. Тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр төрөлжин хөгжих үйл явц  
 D. Шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах үйл явц  
 E. Соёл урлаг боловсролын салбарт хамтран ажиллах үйл явц
34. Манай орны зүүн захын цэгийн уртрагийн солбицолыг зөв сонго. (2 оноо)  
 А. ЗУ 87°44' В. ЗУ 119°56' C. ЗУ 108°47'  
 D. ЗУ 129°16' E. ЗУ 90°24'
35. Тэжээлийн байдал, урсацын горимд үндэслэн гол мөрдийг хэв шинжүүдэд хуваадаг. Зуны борооны улиралд дүүрэн устай, харин халуун агаарын цул ноёрхох үед түвшин нь багасан, бараг хатаж ширгэдэг голууд аль хэв шинжид хамрагдах вэ? (2 оноо)  
 А. Экваторын В. Тропикийн цөлийн C. Субэкваторын  
 D. Туйлын E. Нуурын
36. ХӨ-ийн 36°-40° -ын хооронд орших байрзүйн зургийн хуудасны эгнээг ямар үсгээр төлөөлж бичих вэ? (2 оноо)  
 А. К үсэг В. L үсэг C. I үсэг  
 D. J үсэг E. A үсэг
37. Хөгжиж буй орнуудын үйлдвэрлэх хүчний байршлын ерөнхий шинж аль нь вэ? (2 оноо)  
 А. Нийслэл ба аль нэг боомт хотуудад хүн ам, ачаа тээвэр, боловсруулах үйлдвэрүүд нь хүчтэй төвлөрсөн  
 В. Аж үйлдвэр, ХАА-н салбарууд нь нутаг дэвсгэрээр тэнцвэртэй хөгжсөн  
 С. Үйлдвэрлэлийн салбаруудыг нутаг дэвсгэрээр бүсчлэн төлөвлөгөөтэй хөгжүүлсэн байдаг  
 D. Хот орчмын бүсэд эрчимжсэн хөдөө аж ахуйн бүс бүрэлдэн тогтсон  
 E. Олборлох боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудын орон зайн зохион байгуулалт тэнцвэргүй
38. Томоохон рашаануудыг орших аймагтай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонго. (3 оноо)
- | Дугаар | Рашааны нэр | Индекс | Орших аймаг |
|--------|-------------|--------|-------------|
| 1      | Аварга      | А      | Баянхонгор  |
| 2      | Шаргалжуут  | Б      | Төв         |
| 3      | Жанчивлан   | В      | Өвөрхангай  |
| 4      | Хужирт      | г      | Хэнтий      |
- А. 1б 2в 3г 4а В. 1б 2г 3а 4в C. 1г 2в 3а 4б  
 D. 1г 2а 3б 4в E. 1в 2г 3а 4б
39. Архангай аймагтай хил залгах аймгуудыг зөв сонго. (3 оноо)  
 А. Завхан, Хөвсгөл, Булган, Төв, Баянхонгор  
 В. Завхан, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Баянхонгор  
 С. Завхан, Хөвсгөл, Булган, Увс, Ховд  
 D. Завхан, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Ховд  
 E. Завхан, Хөвсгөл, Булган, Өвөрхангай, Баянхонгор
40. Дараах хойгуудыг орших эх газартай нь зөв харгалзуулсан хувилбарыг сонго. (3 оноо)
- | Дугаар | Газар орны нэр | Индекс | Орших эх газар |
|--------|----------------|--------|----------------|
| 1      | Таймыр         | А      | Африк          |
| 2      | Сомали         | Б      | Хойд америк    |
| 3      | Пиреней        | В      | Еврази         |
| 4      | Юкотан         | г      | Европ          |
- А. 1б 2в 3г 4а В. 1б 2г 3а 4в C. 1г 2в 3а 4б  
 D. 1в 2а 3г 4б E. 1в 2г 3а 4б
41. Дараах үйлдвэр уурхайг олборлож буй ашигт малтмалтай нь зөв тохируулсан хувилбарыг сонго. (3 оноо)
- | Дугаар | Үйлдвэр уурхайн нэр | Индекс | Олборлох ашигт малтмал |
|--------|---------------------|--------|------------------------|
| 1      | Өргөн               | а      | Нүүрс                  |
| 2      | Талбулаг            | б      | Цайр                   |
| 3      | Төмөртэй            | в      | Зэс                    |
| 4      | Оюутолгой           | г      | Хайлуур жонш           |
- А. 1б 2в 3г 4а В. 1б 2г 3а 4в C. 1г 2в 3а 4б  
 D. 1г 2а 3б 4в E. 1в 2г 3а 4б

42. Доорх зурагт L-48 хуудасны залгаа орших тоогоор тэмдэглэсэн хуудасны нэрлэлийг зөв дугуйл. (3 оноо)

- A. 1 М - 48    2 L - 49    3 М - 49  
 B. 1 М - 50    2 L - 49    3 М - 47  
 C. 1 М - 48    2 L - 47    3 М - 50  
 D. 1 М - 48    2 L - 49    3 К - 48  
 E. 1 М - 50    2 L - 49    3 М - 48



43. Улаанбаатар хотоос манай орны байгалийн цогцолборт болон дурсгалт газар болох Алтан овоо - Шилийн богд-Ганга нуур хүрэх хамгийн дөт замыг сонго. (3 оноо)

- A. Улаанбаатар - Чойр - Сайншанд - Баруун-Урт - Алтан овоо  
 B. Улаанбаатар - Өндөрхаан - Чойбалсан - Баруун-Урт - Алтан овоо  
 C. Улаанбаатар - Өндөрхаан - Баруун-Урт - Алтан овоо  
 D. Улаанбаатар - Мандалговь - Чойр - Баруун-Урт - Алтан овоо  
 E. Улаанбаатар - Мандалговь - Сайншанд - Баруун-Урт - Алтан овоо

44. Дараах улс орнуудыг нийслэлтэй нь зөв тохируулсан хувилбарыг сонго. (3 оноо)

Дугаар	Улс орны нэр	Индекс	Нийслэл
1	Канад	А	Гавана
2	Куба	Б	Ла-Пас
3	Ямайка	В	Оттава
4	Болив	г	Кингстон

- A. 1б 2в 3г 4а    B. 1б 2г 3а 4в    C. 1г 2в 3а 4б  
 D. 1в 2а 3г 4б    E. 1в 2г 3а 4б

45. Нэг уртраг дээр орших хоёр хотын хоорондох өргөргийн зөрүү  $9^0$  бол 1:30000000 масштабтай газрын зурагт хоёр хотын хоорондох зай ямар зайтай зурагдах вэ?

(Өргөргийн  $1^0$ -ын өнцөгт тулсан голдожийн нумын урт 111.1 км)

- A. 3.3 см    B. 4.4 см    C. 5.5 см  
 D. 6.6 см    E. 7.7 см

46. Доорх өгөгдлийг ашиглан Алтай хотын чийглэгийн итгэлцүүрийг бодож ол. (3 оноо)

Унах тунадасны хэмжээ 176.9 мм

Уурших чадварын хэмжээ 671 мм

- A. 3.79    B. 0.26    C. 847.9  
 D. 494.1    E. 20

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

#### Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: Бодлогын хариу 1235 гарсан гэж үзвэл a-1, b-2, c-3, d-5 гэж бөглөнө.
- Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээ нь: Бодлогын хариу 21.34 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариултын загварыг [ab,cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө a-2, b-1, c-3, d-4 гэж бөглөнө.


2.1. Орхон гол тодорхой хэсэгтээ 30 м өргөн, 1.5 м гүн, урсгалын хурд нь 4 м/с бол усны зарцуулгыг ол. (4 оноо)

2.2. Далайн мандалд орших усан онгоцноос далайн ёроол руу дууны долгион илгээхэд илгээсэн долгион 10 секундын дараа эргэж ирсэн бол далайн мандлаас ёроол хүртэлх зайг ол. (Усанд дууны долгион тархах хурд 1500 м/с)

(4 оноо)

2.3. Анхны голдоч дээр 09:00 цаг болж байхад аль уртраг дээр 04 : 00 цаг болж байх вэ?

(4 оноо)




- 2.4. Бархасбадь гаригийн нарнаас алслагдах зай одон орны нэгжээр 5.20 бол энэ гаригийн нарыг тойрох орбитийн хугацаа нь дэлхийн жилээр [ab,cd] байна. (4 оноо)  
(Кеплерийн III хууль үндэслэн бодно)

### ХУВИЛБАР С

#### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нар аль өргөрөг дээр эгц тусах үеийг монголчууд “Нар буцах өдөр” гэж нэрлэдэг вэ? (1 оноо)  
 А. ХӨ-ийн 23.5° буюу Мэлхийн зам  
 В. ӨӨ-ийн 23.5° буюу Матрын зам  
 С. 0° -ийн өргөрөг буюу Экватор  
 D. ХӨ-ийн 66.5° буюу Хойд туйлын цагираг  
 E. ӨӨ-ийн 66.5° буюу Өмнөд туйлын цагираг
2. Дараах зурагт Калимантан арлыг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ? (1 оноо)

- A. 1  
 B. 2  
 C. 3  
 D. 4  
 E. 5




3. Өмнөговь аймгийн нутагт орших Тавантолгойн коксждог нүүрсний орд аль галавт үүссэнийг сонго. (1 оноо)  
 А. Триас  
 В. Пермь  
 С. Девон  
 D. Силур  
 E. Кембри
4. НҮБ-ын Шинжлэх Ухаан, Боловсрол, Соёлын байгууллагын “Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ”-нд манай улсаас аль дархан газрууд бүртгэгдсэн вэ? (1 оноо)  
 А. Дорнод тал  
 В. Ханхэнтий  
 С. Увс нуурын ай сав  
 D. Нөмрөг  
 E. Говийн бага
5. Африкийн гадаргын дундаж өндөр аль нь вэ? (1 оноо)  
 А. 830  
 B. 750  
 C. 720  
 D. 580  
 E. 2040
6. Зорчигч тээвэр гэж юу вэ? (1 оноо)  
 А. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замаар нь үржүүлсэн үзүүлэлт  
 B. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээ  
 C. Зорчсон хүний тоог явсан замын уртаар үржүүлсэн үзүүлэлт  
 D. Нийт зорчсон хүний тоо  
 E. Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг явсан замд хуваасан үзүүлэлт

**Боловсролын Үнэлгээний Төв**

7. Манай оронтой нэг уртрагт орших улс аль нь вэ? (1 оноо)  
А. Герман В. Мексик С. Тайланд  
D. Пакистан E. Япон
